



“ОЛЛОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026.01.05

Дугаар Т26/01

Улаанбаатар хот

“Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийг үндэслэн, Төлөөлөн удирдах зөвлөлийн саналыг хэлэлцэж, санхүүгийн байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр 2026 онд ногдол ашиг хуваарилахгүй байх шийдвэрийг гаргав.”

ТУЗ- ИЙН ДАРГА



Л.БҮҮВЭЙБААТАР



“ОЛЛОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026.01.05

Дугаар Т26/03

Улаанбаатар хот

Монгол Улсын “Компанийн тухай” хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.2, 60.4, 62 дугаар зүйлийн 62.1.7, 62.1.9, 62.1.14, 62.1.15 дахь заалт, 64 дүгээр зүйлийн 64.2, 64.4, 65 дугаар зүйлийн 65.3, 65.4 дэх заалт, 67 дугаар зүйл, 71 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 02 дугаар сарын 27 өдрийн 16:00 цагт “Оллоо ХК”-ын оффис СБД, 8-р хороо, ЛЮКС центрийн 3 давхар 305 тоотод зарлан хуралдсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй:
 - 2.1 Компанийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг хэлэлцэн батлах;
 - 2.2 Компанийн 2026 оны зардлын төсөв батлах;
 - 2.3 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлах;
 - 2.4 ТУЗ-ийн гишүүдийг сонгох;
 - 2.5 Компанийн шинээр батлагдсан логог танилцуулах;
 - 2.6 Ногдол ашиг хуваарилахгүй ТУЗ-ын тогтоолыг танилцуулах;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын даргаар “Макс импекс” ХХК-ын мэдээллийн аюулгүй байдлын инженер Ц.Энхтөр, “Есөн финанс” ББСБ-н ерөнхий нягтлан У.Нарангэрэл, “Бамбуу” хүүхдийн театрын менежер М.Ганди (зөвшилцсөнөөр) нарыг томилсугай.
4. “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдэл”-ийг 1 дүгээр хавсралтаар баталж, 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн дотор багтаан Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар”-ыг 2 дугаар хавсралтаар баталж, 2026 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр, 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр тус тус

өөрийн цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сониноор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэлээлэл хүргүүлсүгэй.

- 5 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор багтаан хувьцаа эзэмшигчидтэй харилцаж буй брокер дилерийн компанид хүргүүлсүгэй.
- 6 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөр тогтсугай.
- 7 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн дарга П.Бүүвэйбаатар, нарийн бичгээр ТУЗ-н хараат бус гишүүн Г.Энхтөр нарыг тус тус томилсугай.
- 8 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар “Оллоо” ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Уламбаяр, комиссын гишүүдэд технологи хөгжүүлэлтийн албаны менежер С.Баясгалан, оффисийн менежер Ц.Бөртэжин нарыг тус тус томилсугай.

ТУЗ- ИЙН ДАРГА



П.БҮҮВЭЙБААТАР